

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН АЖЛЫН БАЙРНЫ СУЛ ОРОН ТООГ

НӨХӨХ ТУХАЙ

Нэг. СУЛ ОРОН ТООГ НӨХӨХ ЗАР

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5-д “Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй” гэсний дагуу Эрүүл мэндийн газрын сул орон тоог нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлөөс нийтэд зарлаж байна.

Зарлагдаж буй сул орон тоонд Төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчид болон төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэй, тухайн албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангасан, энэ албан тушаалд ажиллахыг хүссэн Монгол Улсын иргэн санал хүсэлтээ гаргаж болно.

Нийтэд мэдээлж байгаа энэхүү төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын дагуу нөхөх үйл ажиллагааг зохион байгуулна.

Төрийн албаны зөвлөл зарын дагуу бүртгүүлсэн нөөцөд байгаа иргэнийг тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж байна гэж үзсэн тохиолдолд мэргэшлийн шалгалт өгсөн төрийн жинхэнэ албан тушаалын ангилал дотор төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж болно. Өөрөөр хэлбэл туслах түшмэлийн ангилалд хамаарах ажлын байранд шалгалт өгсөн бол дэс түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдон ажиллах боломжгүй юм.

Хоёр. БҮРТГЭЛИЙН ХУГАЦАА

Нийтэд мэдээлж байгаа энэхүү төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоонд ажиллахыг хүссэн иргэд Эрүүл мэндийн газар/1-р эмнэлгийн урд талд байрлах/-ын 203 тоот өрөөнд 2012 оны 03 дугаар сарын 12-13-ны хооронд 09.30-12.30, 14.00-17.00 цагийн хооронд өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.

Иргэд бүртгүүлэхдээ өөрийн боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар, тусгай шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг үнэн зөв, товчилсон нэр, томьёо хэрэглэхгүй мэдээлэх шаардлагатай. Мөн холбоо барих утасны дугаар, гэрийн хаяг, e-майл хаяг зэргийг тодорхой дурдана.

Гурав. БҮРТГҮҮЛЭХ ИРГЭДЭД ТАВИХ ШААРДЛАГА

1. Бүртгүүлэх иргэн Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn гэсэн цахим хаягт байгаа “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-тай заавал танилцсан байна.
2. Бүртгүүлэгч хуурамч баримт материал бүрдүүлэхгүй, худал мэдүүлэхгүй байх үүрэг хүлээнэ.
3. Бүртгүүлэх иргэн дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ.

- Тухайн албан тушаалд ажиллахыг хүссэн өргөдөл /Иргэн ажилд орохыг хүссэн өргөдөлдөө төрийн албаны мэргэшлийн шалгалтыг хэдэн оны хэдэн сард хаана, ямар байгууллагад өгч тэнцсэн тухай дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ/
- Төрийн албан хаагчийн анкет /Төрийн албан хаагчийн анкетыг маягт N1-ийн дагуу бүрэн бөглөсөн байх/
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эхийг хуулбарын хамт
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн эхийг хуулбарын хамт
- Иргэний үнэмлэхний эх, хуулбарын хамт
- “4х6”-гийн хэмжээний цээж зураг 4 хувь
- Ажилласан хугацаа болон ажил эрхлэлтийг гэрчлэх баримт /Нийгмийн даатгал, хөдөлмөрийн дэвтэр/-ын эх хувь

Жич:

Мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн иргэний нөөцийн бүртгэл 2 жилийн хугацаанд хүчинтэй байх ба зөвхөн мэргэшлийн шалгалт өгсөн албан тушаалын ангилал дотроо нэр дэвшинэ гэдгийг анхаарна уу.

Дөрөв. МЭДЭЭЛЭЛ ЛАВЛАГАА

Тус байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоонд ажиллах хүсэлтэй иргэд 93131766, 70128801 дугаарын утсаар холбогдож лавлагаа авч болно.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТОО БОЛОН АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Дэс дугаар	Байгууллагын нэр	Нэгжийн нэр	Ажлын байрны				Ажлын байранд тавигдах шаардлага						Тайлбар
			нэр	хариуцсан асуудал	ангилал, зэрэглэл	орон тоо	боловсрол	мэргэжил	мэргэшил	туршлага	ур чадвар	тусгай шаардлага	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
1	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн хэлтэс	Мэргэжилтэн	Хөдөлмөрийн норм, норматив	ТЗ-6	1	Дээд, бакалавр зэрэгтэй	Хөдөлмөрийн эдийн засагч, Хүний их эмч, Эрүүл ахуйч		Мэргэжлээр ээ 1-ээс доошгүй жил ажилласан	Үүрэг, хариуцлага хүлээх, өөрийгөө хөгжүүлэх, асуудал боловсруулах, багаар ажиллах, англи, орос хэлний мэдлэгтэй, компьютерийн өргөн хэрэглээний програмуудыг сайн эзэмшсэн. Интернетийн орчинд ажиллах, дотоод сүлжээг бүрэн ашигладаг.	Хөдөлмөрийн харилцаа, норм, нормативын чиглэлээр сургалтад хамрагдсан. Судалгааны арга зүй эзэмшсэн.	ЭМГ-ын даргын 2011 оны 242 дугаар тушаалар энэхүү ажлын байр бий болсон.
2	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар	Эмнэлгийн техник, технологи, эдийн засгийн хэлтэс	Мэргэжилтэн	Эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн дүн шинжилгээ	ТЗ-6	1	Дээд, бакалавр зэрэгтэй	Эдийн засагч, Нягтлан бодох бүртгэл		Мэргэжлээр ээ 2-оос доошгүй жил ажилласан	Үүрэг, хариуцлага хүлээх, өөрийгөө хөгжүүлэх, асуудал боловсруулах, багаар ажиллах, англи, орос хэлний мэдлэгтэй, компьютерийн өргөн	Судалгааны арга зүй эзэмшсэн.	ЭМГ-ын даргын 2011 оны 242 дугаар тушаалар энэхүү ажлын байр бий болсон.

											хэрэглээний програмуудыг сайн эзэмшсэн. Интернетийн орчинд ажиллах, дотоод сүлжээг бүрэн ашигладаг.		
3	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар	Эмнэлгийн техник, технологи, эдийн засгийн хэлтэс	Мэргэжилтэн	Эрүүл мэндийн эдийн засгийн дүн шинжилгээ	ТЗ-6	1	Дээд, бакалавр зэрэгтэй	Эдийн засагч		Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан	Үүрэг, хариуцлага хүлээх, өөрийгөө хөгжүүлэх, асуудал боловсруулах, багаар ажиллах, англи, орос хэлний мэдлэгтэй, компьютерийн өргөн хэрэглээний програмуудыг сайн эзэмшсэн. Интернетийн орчинд ажиллах, дотоод сүлжээг бүрэн ашигладаг.	Судалгааны арга зүй эзэмшсэн.	ЭМГ-ын даргын 2011 оны 242 дугаар тушаалар энэхүү ажлын байр бий болсон.
4	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар	Эрүүл мэндийн статистикийн хэлтэс	Мэргэжилтэн	Хувийн хэвшлийн эмнэлгийн статистик мэдээ	ТЗ-6	1	Дээд, бакалавр зэрэгтэй	Хүний их эмч, Хүн ам зүйч, НЭМ-ийн ажилтан	Тархвар зүйч, биостатистик, НЭМ-ийн аль нэгээр мэргэшсэн.	Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан	Үүрэг, хариуцлага хүлээх, өөрийгөө хөгжүүлэх, асуудал боловсруулах, багаар ажиллах, англи, орос хэлний мэдлэгтэй, компьютерийн өргөн хэрэглээний		ЭМГ-ын даргын 2011 оны 242 дугаар тушаалар энэхүү ажлын байр бий болсон.

											програмуудыг сайн эзэмшсэн. Интернетийн орчинд ажиллах, дотоод сүлжээг бүрэн ашигладаг.		
5	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар	Эмийн бүртгэлийн хэлтэс	Мэргэжилтэн	Биологийн идэвхит бүтээгдэхүүний хэрэглээ	ТЗ-6	1	Дээд, бакалавр зэрэгтэй	Хүний их эмч, Эрүүл ахуйч, Эм зүйч, Хүнсний мэргэжилтэйд холбоотой бусад		Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан	Үүрэг, хариуцлага хүлээх, өөрийгөө хөгжүүлэх, асуудал боловсруулах, багаар ажиллах, англи, орос хэлний мэдлэгтэй, компьютерийн өргөн хэрэглээний програмуудыг сайн эзэмшсэн. Интернетийн орчинд ажиллах, дотоод сүлжээг бүрэн ашигладаг.	Хувьдаа эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжгүй байх.	ЭМГ-ын даргын 2011 оны 242 дугаар тушаалар энэхүү ажлын байр бий болсон.

ТӨВ КОМИСС